



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2020 оны 12 сарын 08 өдөр

Дугаар 673

Улаанбаатар хот

┌ Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах ┐  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2, 6.4.4, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дорноговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 2 нэрийн нийт 21,500.00 (хорин нэгэн мянга таван зуун) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Дорноговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Ж.Наранболд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийн хамт 2021 оны 1 дүгээр улиралд багтаан тайлагнах.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



13301443

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын  
газрын 2020 оны 12 дугаар сарын 23 ны өдрийн  
073 дугаар тогтоолын хавсралт

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД  
БҮРТГЭЛТЭЙ АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

| Д/д             | Хөрөнгийн нэр             | Ашиглалтад орсон он | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ | Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл   |
|-----------------|---------------------------|---------------------|-------------|------------|----------------|---------------------------------------|
|                 |                           |                     |             |            | (төгрөг)       |                                       |
| 1               | Буу /карбин/              | 1980.01.01          | ш           | 1          | 1,500.00       | 1,500.00                              |
| 2               | Граж /1 автомашины модон/ | 1972.01.01          | ш           | 1          | 20,000.00      | 20,000.00                             |
| <b>Нийт дүн</b> |                           |                     |             |            |                | <b>21,500.00</b>                      |
|                 |                           |                     |             |            |                | <b>(хорин нэгэн мянга таван зуун)</b> |